



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүн”

**ХУУЛЬ, ЖУРМААР ТОГТООСОН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ХЭМЖЭЭ НЬ
ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХ, НЭМЭГДҮҮЛЭХЭД ХӨШҮҮРЭГ БОЛЖ
ЧАДАХГҮЙ БАЙНА.**

Аудитын код: ДГА-2025/39-ШТА-ГА

Цахим хуудас:
www.audit.mn
Дорноговь аймаг
2025 оны 09 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер:

Утас: 70523020

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор:

Э.Энхцэцэг

Цахим хаяг: enkhsetsege@audit.gov.mn

Аудитор:

Б.Ариунбаатар

Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МУ-ын Ерөнхий аудиторын 2024 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаалд тусгасны дагуу тус аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын зорилго: Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Орон нутагт хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа болон зарцуулах хөрөнгийг хууль, тогтоомжид нийцүүлж, үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ: Аудитад аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023, 2024 оны үйл ажиллагаа болон ХЭДС-ийн үйл ажиллагаанд оролцогч ААНБ, иргэдийг хамруулан аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа: Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлэн, ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Б.Ариунбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитыг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлүүлэн, аудитын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулж, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг хэрэгжүүлэн, тайланг дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр хүргүүлсэн.

Ерөнхий мэдээлэл: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг 2023 онд 1,381.4 сая төгрөгөөр баталж 1,033.0 сая төгрөг зарцуулсан бол 2024 онд 2,921.6 сая төгрөгөөр баталж, 2,146.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж 2023 онд 93 иргэнд 712.9 сая төгрөг, 2024 онд 202 иргэнийг хамруулан, 1,694.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ХЭДС-аас олгосон санхүүгийн дэмжлэгийн мэдээлэл

Хүснэгт №1

/сая төгрөг/

Д/д	Хөтөлбөрийн нэр	2023 он		2024 он	
		Хамрагдсан иргэний тоо	Олгосон дэмжлэгийн дүн	Хамрагдсан иргэний тоо	Олгосон дэмжлэгийн дүн
1	Малжуулах санхүүгийн дэмжлэг	18	90,000.00	118	968,000.00
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэг	16	144,000.00	16	128,000.00
3	Залуучуудад олгосон санхүүгийн дэмжлэг	1	10,000.00	1	10,000.00
4	Ахмадад олгосон санхүүгийн дэмжлэг	20	100,000.00	28	200,800.00
5	ХХЭ-д олгосон санхүүгийн дэмжлэг	38	368,900.00	39	388,000.00
Нийт		93	712,900.00	202	1,694,800.00

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох үйл ажиллагааг банкаар дамжуулан гүйцэтгүүлэх арга хэмжээний хүрээнд 2024 онд ХААН, Төрийн банктай хамтран 10 иргэнд 192.0 сая төгрөгийн жижиг зээлийг олгож, 15 байнгын ажлын байр

бий болгож, санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 193 иргэнийг хамруулан 311 иргэнийг ажлын байртай болгосон байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хэрэгжилтийг хангах зорилтын ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах арга хэмжээний хүрээнд бүлгийн сургалтад 1000 сурагч, ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээнд 400 иргэн, бусад 7 төрлийн арга хэмжээгээр 721 сурагчийг, хөдөлмөрт бэлтгэх сургалтад 409 иргэнийг хамруулснаар 86 иргэн ажлын байраар хангагдсан байна.

Ажил хайгч иргэдийг ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тохирсон ажлын байранд зуучлах үйлчилгээний хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд цагийн болон өдрийн ажил хийх сонирхолтой нийт 157 оюутан, ажилгүй иргэдийн судалгааг гарган, мэдээллийн сан үүсгэж, 26 ААНБ, 111 иргэнээс 153 ажлын байрны захиалга авч, 106 иргэнийг цагийн болон өдрийн ажлын байранд зуучилсан, түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд 741 иргэнийг хамруулан түр ажлын байраар хангасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн цахим e-job системд шинээр бий болсон ажлын байрыг бүртгэх, мэдээлэх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлснээр 2024 оны жилийн эцсийн байдлаар 1459 шинэ ажлын байрыг бүртгэсэн байна.

БҮЛЭГ.1. САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ БОЛОМЖИТ ХЭМЖЭЭГЭЭР БОДИТОЙ ТӨЛӨВЛӨСНӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАР ХҮРЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийг орон нутгийн бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөж, батлах шаардлагатай байна.

1.1.1 Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа, мэдээллийн баазыг шинэчлэн баяжуулж, үндэслэлтэй төлөвлөх шаардлагатай байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30.3.3 “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах ажил олоход хүндрэлтэй иргэдийн талаарх мэдээлэл, судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”,

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.2.12 “Энэ хуулийн 5.1-д заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зарчмыг төлөвлөлтийн дээрээс доош төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх гэсэн агуулгаар ойлгоно”, 6.10.4 “Орон нутгийн төсөв нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх шаардлагыг хангасан байна” гэж тус тус заасан.

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023, 2024 оны төлөвлөгөөнд орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох талаар дараах арга хэмжээг тусгаж, арга хэмжээний зорилтот түвшинг ХХҮЕГ-ын даргын 2023 оны А/37, 2024 оны А/265 дугаар “Хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн хуваарь батлах тухай” тушаалын хавсралтад тусгагдсан тухайн онуудад хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах иргэдийн тоонд үндэслэн төлөвлөсөн байна.

“Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний мэдээлэл

Хүснэгт №2

Зорилтын дугаар	Зорилтын агуулга	Арга хэмжээний тоо	Зорилтот түвшин	
			2023 он	2024 он
2.5.3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ядуурлыг бууруулан, цахим системд үе шаттай шилжүүлэх	2	1400	-
2.5.4	Орон нутгийн бүтээн байгуулалтын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэ ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тогтмол нэмэгдүүлэх	4	2230	-
2.5.5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангах	1	-	-
2.5.6	Залуучуудад бизнес эрхлэхэд зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, тусалцааг үзүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх	2	530	-
2.1	Ажилгүйдлийн түвшинг бууруулах	7	-	3405
4.1	Гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг хангах	4	-	4571
4.2	Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх	9	-	1195

ХХҮЕГ-ын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн “EJOB” нэгдсэн цахим системийг 2023.01.01-ний өдрөөс нэвтрүүлснээр 2023 оны жилийн эцсийн байдлаар тус системд 323 ажил олгогч, 1545 ажлын байрны захиалга, 2227 ажил хайгч иргэн, 1450 шинээр бий болсон ажлын байр, 1221 иргэнийг ажилд зуучилсан мэдээллийг тус тус бүртгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2023, 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр тодорхой зорилтын хүрээнд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч орон нутаг дахь хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, тус арга хэмжээнд хамрагдах иргэдийн талаар бодит тоо мэдээлэлд үндэслэн судалгаа хийгээгүй байна.

Энэ нь аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.1.3-т заасан “Аймгийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэсэн чиг үүргийг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Аймгийн Засаг дарга хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах иргэдийн судалгааг гаргах, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох эрхийн хүрээнд салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэгч байгууллага, ажил олгогч ААНБ, иргэдтэй мэдээлэл солилцох байдлыг сайжруулж, дүн мэдээг нэгтгэн, мэдээллийн баазыг бүрдүүлж, баяжуулснаар орон нутагт ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаа, зарцуулах хөрөнгийг бодитой, үр дүнтэй төлөвлөх нөхцөл бүрдэхээр байна.

1.1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг орон нутагт салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөх шаардлагатай байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.10.4 “Аймгийн Засаг даргын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар сумын түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй”,

Аймгийн Засаг даргын 2024 оны А/661 захирамжаар “Түншлэл ба хөгжил” бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтот хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журмыг баталсан ба тус журмын 4.1.4 *“Татвар болон зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх”*, 4.1.6 *“Урьд нь төсөл хөтөлбөрт хамрагдан төсөл хэрэгжүүлж байсан бол үр дүн нь гарсан байх”* гэж заасан.

Гэтэл ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй, хугацаа хэтэрсэн өр төлбөрийн үлдэгдэлтэй 6 иргэнд дээрх хөнгөлөлттэй зээлийг олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 *“Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Зөвлөлийн өмнө бүрэн хариуцна”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ИТХ-аар аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023, 2024 оны хэрэгжилтийг тоон үзүүлэлтээр харьцуулан үр дүнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, хэлэлцүүлэн дүгнэсэн байх боловч тухайн зорилтын хангагдсан бодит нөхцөл байдал болон хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж, хамтран зохион байгуулсан байдал, зардлын эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэсэн зэргийг тодорхой үзүүлэлтээр үнэлээгүйтэй холбоотой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн үр дүн тодорхойгүй байна.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь ХЭДС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын төлөвлөлттэй холбоотой эрх, үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.2.1. ХЭДС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн төлөвлөх боломж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т *“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү, ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө болон бусад эх үүсвэрээс бүрдэнэ”*,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т *“Төсвийн зарчмыг хэрэгжүүлэхдээ жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”*, 27 дугаар зүйлийн 27.1.2-т *“Төсвийн төсөл боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх шаардлагыг хангасан байна”* гэж тус тус заасан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нийт орлогыг 2023 онд 1,381.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,224.4 сая төгрөг, 2024 онд 2,921.6 сая төгрөгийг төлөвлөж 3,518.4 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №4

/сая төгрөг/


“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүн” - ГА

Үзүүлэлт	2023 он		2024 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	130.0	280.1	132.0	211.7
ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт	1,251.4	1,251.5	2,454.6	2,458.6
Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	-	435.2	-	513.1
Өмнөх оны үлдэгдэл	-	257.6	334.9	334.9
Нийт орлого	1,381.4	2,224.4	2,921.6	3,518.4
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	36.8	25.6	29.0	19.8
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ	1125.1	934.7	2,336.2	2,050.1
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	89.5	72.7	89.5	76.5
Төвлөрүүлэлт	130.0	1,191.4	466.9	1,371.9
Нийт зардал	1,381.4	2,224.4	2,921.6	3,518.3

ХХҮЕГ нь аймгийн ХХҮГ-ын тайлант хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо хэмжээ, олгох санхүүжилтийг баталсан боловч ХЭДС-ийн орлогын эх үүсвэрийг хуульд заасан дараах төрлөөр төлөвлөх боломжийн талаар чиглэл өгөөгүй байна.

- **Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт:** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 2014 оноос хойш хамрагдсан 456 иргэнтэй холбоотой 2,256.4 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг ХЭДС-д төвлөрүүлж, дахин хуваарилалт хийхээр төлөвлөөгүй ба нийт авлагын төлөв байдлыг авч үзэхэд гэрээний хугацаа дуусаж хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн 81 иргэнтэй холбоотой 286.1 сая төгрөг, нас барсан 8 иргэнтэй холбоотой 20.7 сая төгрөг, хуваарийн дагуу төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн 160 иргэний 1,006.0 сая төгрөг, үлдэгдлийг төлүүлэх талаар арга хэмжээ авч шийдвэрлээгүй 20 иргэний 35.0 сая төгрөг, харин 187 иргэний 908.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хэвийн төлөгдөж байна.

Дүрслэл №1




- **Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр:** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.7 “ХЭДС-ийн орлогын эх үүсвэр нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй ААНБ-аас төлөх төлбөрөөс бүрдэнэ”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.3 “Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу бий болгож ажиллуулах үүрэгтэй”, Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2 “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж,

байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна” гэж заасан.

Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар 25-аас дээш орон тоотой 150 ААНБ үйл ажиллагаа явуулж байгаагаас ХБИ ажиллуулаагүй 40, ажиллуулбал зохих хэмжээнээс 1-32 орон тоогоор бага ажиллуулсан 52, 1-5 орон тоог илүү ажиллуулсан 30 байгууллага, харин 26 байгууллага зохих орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

ХБИ-ийг ажлын байраар хангасан тухай мэдээлэл

Дүрслэл №2



Эх сурвалж: Нийгмийн даатгалын газрын 2024 оны мэдээлэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 2024 онд 132.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 211.7 сая төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 160.3 хувиар биелүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах хуулийн шаардлага хангасан нийт 150 ААНБ байгаагаас 8 хувь буюу 12 ААНБ-аас ХЭДС-ийн 2024 оны орлогын төлөвлөгөөг бүрдүүлсэн байгаа нь ХБИ ажиллуулахгүй байгаа 138 ААНБ-аас хуульд заасан төлбөрийг ногдуулахаар төлөвлөж, төвлөрүүлэх боломж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29.9.7 “Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага энэ хуульд зааснаас гадна аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээний судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэсэн чиг үүргийн хүрээнд аймгийн ХХҮГ нь 2022 онд аймгийн ЗДТГ-тай хамтарсан, мөн 2023 онд МХНМХ-той ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ХЭДС-ийн эх үүсвэрээр хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийх ажлыг хэрэгжүүлсэн боловч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг төлөвлөхөд тус судалгаанд үндэслээгүй байна.

Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааны дүнд үндэслэн зардлыг бодитой төлөвлөх, мөн ХЭДС-ийн эх үүсвэрийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэн төлөвлөж, төвлөрүүлснээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдэхээр байна.

1.2.2. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь зөвлөлийн дүрэмд заасан эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны II тогтоолын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм"-ийн 2-т зөвлөл нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, төрийн бодлогын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх талаар санал боловсруулж ИТХ, холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, ЗДТГ, бусад нэгжүүдийн ажлыг уялдуулан зохицуулах, ХЭД дэд сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах асуудал хэлэлцэж зөвлөмж гаргах бүрэн эрхийг заасан.

Гэтэл Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь аудитад хамрагдсан онуудад тус бүр нэг удаа хуралдаж 2023 онд 6, 2024 онд 5 асуудлыг хэлэлцсэн байх ба зөвлөлийн дүрмийн 2.2.1-т заасан ХЭДС-д орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар зарцуулагдах хөрөнгийг аймгийн төсөвт жил бүр тусган батлуулах, 2.2.2-т заасан аймгийн хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, хөтөлбөр, ХЭДС болон аймаг, орон нутгийн онцлогтой хөтөлбөрийг боловсруулан батлуулах ажлыг санаачлан зохион байгуулах үүргийг хэрэгжүүлээгүй байна


БҮЛЭГ.2. ХУУЛЬ, ЖУРМААР САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХ, НЭМЭГДҮҮЛЭХЭД ХӨШҮҮРЭГ БОЛОХУЙЦ ХЭМЖЭЭГЭЭР ТОГТООГООГҮЙ БАЙГАА НЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

2.1. Хууль, журмаар тогтоосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээнээс шалтгаалан бага төсөвтэй олон төслийг санхүүжүүлж байгаагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үндсэн зорилго хангагдаагүй байна.

2.1.1 Нийтлэг үйлчилгээ болон дэмжих арга хэмжээг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан хэдий ч ХХҮГ-ын дотоод үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл хэлбэрийг дараах байдлаар заасан. Үүнд:

Дүрслэл №3



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч энэ хуульд заасны дагуу хамрагдана” гэж заасан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг авч үзэхэд 2023 онд нийт 1,008 иргэнийг хамруулж 934.7 сая төгрөг, 2024 онд 1309 иргэнийг хамруулж 2,050.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилт

Хүснэгт №6

/сая төгрөг/

№	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ	2023 он				2024 он			
		Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
		Хүнээр	Мөнгөн дүн	Хүнээр	Мөнгөн дүн	Хүнээр	Мөнгөн дүн	Хүнээр	Мөнгөн дүн
1	Хөдөлмөрт бэлтгэх	349	36.3	386	27.6	543	39.3	278	22.8
2	Иргэнд олгох дэмжлэг	40	400.0	38	368.9	40	400.0	39	388.0
3	Малжуулах дэмжлэг	20	100.0	18	90.0	125	975.7	118	968.0
4	Ахмадад олгох санхүүгийн дэмжлэг	20	100.0	20	100.0	30	240.0	28	208.8
5	Шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	2	18.0	1	16.0	2	18.0	1	18
6	Ажил олгогчийг дэмжих	3	15.1	1	5.0	2	15.1	-	-
7	Түрээсийн дэмжлэг үзүүлэх	12	14.4	-	-	6	14.7	6	7.2
8	Борлуулалтын дэмжлэг үзүүлэх	-	7.2	15	7.2	-	-	-	7.5
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	79	165.4	16/72	157.3	86	142.8	16/98	135.8
9	Ахмад настны зөвлөх үйлчилгээ	8	8.6	4	4.3	55	59.4	7	5.9
10	Мод тарих	500	200.0	230	104.4	150	60.0	94	37.3
11	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах	150	60.0	223	54.0	838	335.2	640	250.8
Нийт дүн		1,183	1,125.0	1,008	934.7	1,875	2,297.8	1,309	2,050.1

Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн сургалт, ажил олгогчийг дэмжих хэлбэрээр зохион байгуулж хэрэгжүүлнэ” гэж заасан.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэхэд ЕБС-ийн сурагчид, иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх бүлгийн сургалтыг зохион байгуулж 2023 онд нийт 1,400 иргэнийг хамруулан 16.9 сая төгрөг, 2024 онд мөн 1,400 иргэдийг хамруулж 17.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний гүйцэтгэл

Хүснэгт №7

№	Хамрах он	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ		Ажилд зуучлал	Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах
		Бүлгийн сургалт /хүний тоо/	Ганцаарчилсан зөвлөгөө		
1	2023	1,000	400	1,221	2,347
2	2024	1,000	400	916	3,340
Нийт		2,000	800	2,137	5,687

Мөн ажилд зуучлах үйлчилгээний хүрээнд 2023 онд 2,650 иргэнийг хамруулахаас 1,221 иргэнийг хамруулж 8.7 сая төгрөг, 2024 онд 2,100 иргэнийг хамруулахаас 916 иргэнийг хамруулж 2.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Монгол Улсын ЗГ-ын 2024 оны 209 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулж, тус журмын 5.1.1-т заасны дагуу 2024 онд 125 өрхөд 975.7 сая төгрөгийн дэмжлэг олгохоор баталж, ба 118 иргэнд 968.0 сая төгрөгийн дэмжлэг, тус журмын 5.10.1-т заасны дагуу 2024 онд ахмад, залуучууд, иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг нийт 166 төсөлд 750.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4.1.1-т заасан зарчмыг баримтлан жилд дунджаар 400 орчим иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөгөөнд хамруулж, 1221 иргэнийг ажилд зуучилсан байна.

ХЭДС-ийн хөрөнгөөр орон нутагт төлөвлөсөн тодорхой үйл ажиллагаануудыг зохион байгуулж байгаа хэдий ч ажилгүй иргэдийн сурч мэргэшэх, хөдөлмөр эрхлэх, ажлын байр, тогтмол орлоготой болох хүсэл эрмэлзэл, мөн ХЭДС-аас иргэдийн бизнесийг дэмжих чиглэлээр олгож байгаа дэмжлэгийн санхүүжилтийн хэмжээ нь шинэ төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж бэлтгэх, ажлын байр барих, худалдан авах хэмжээний эх үүсвэрийг бүрдүүлж чадахгүй байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд нөлөөлж байна.

2.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн үйл ажиллагааны үр дүн, нөхцөл байдалд тухай бүр дүн шинжилгээ хийгээгүй, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, асуудлыг тухай бүр шийдвэрлээгүйгээс зарцуулалттай холбоотой зөрчил гарсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “Төсвийн зарчмыг хэрэгжүүлэхдээ жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 27 дугаар зүйлийн 27.1.2-т “Төсвийн төсөл боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх шаардлагыг хангасан байна” гэж заасан.

ХЭДС-ийн нийт орлогыг 2023 онд 1,381.2 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2,224.4 сая төгрөг, 2024 онд 2,921.6 сая төгрөгийг төлөвлөж, 3,518.4 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.


ХЭДС-ийн эх үүсвэр болон зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №8

Үзүүлэлт	2023 он		/сая төгрөг/ 2024 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	130.0	280.1	132.0	211.7
ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт	1,251.4	1,251.5	2,454.6	2,458.6
Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	-	435.2	-	513.1
Өмнөх оны үлдэгдэл	-	257.6	334.9	334.9
Нийт орлого	1,381.4	2,224.4	2,921.6	3,518.4
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	36.8	25.6	29.0	19.8
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ	1125.1	934.7	2,336.2	2,050.1
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	89.5	72.7	89.5	76.5
Төвлөрүүлэлт	130.0	1,191.4	466.9	1,371.9
Нийт зардал	1,381.4	2,224.4	2,921.6	3,518.3


ХЭДС-ийн зардлын гүйцэтгэлийг авч 2023 онд 1,381.2 сая төгрөгийн зардал төлөвлөж 2,224.4 сая төгрөгийг зарцуулсан, үүнээс 1.2 хувь буюу 25.6 сая төгрөгийг нийтлэг үйлчилгээнд, 42 хувь буюу 934.7 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд, 3.3 хувь буюу 72.7 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, 53.6 хувь буюу 1,191.4 сая төгрөгийг дээд шатны захирагчид төвлөрүүлсэн байна.

ХЭДС-ийн нийт зардлын гүйцэтгэл 2023 он /хувиар/



Дүрслэл №5


ХЭДС-ийн нийт зардлын гүйцэтгэл 2024 он /хувиар/



Харин 2024 онд 3,518.4 сая төгрөгийн зардал төлөвлөж 3,518.3 сая төгрөгийг зарцуулсан, үүнээс 0.6 хувь буюу 19.8 сая төгрөгийг нийтлэг үйлчилгээнд, 58.6 хувь буюу 2,060.0 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд, 1.9 хувь буюу 66.6 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, 39.0 хувь буюу 1,371.9 сая төгрөгийг дээд шатны захирагчид төвлөрүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч 38 иргэнд 368.9 сая төгрөг, малчдыг малжуулах төслийн хүрээнд 18 иргэнд 90.0 сая төгрөг, залуучуудыг дэмжих “Старт-ап” төслийн хүрээнд 1 иргэнд 10.0 сая төгрөг, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 20 ахмадыг хамруулан 100.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 50 хувийн хөнгөлөлттэй зээлд 16 иргэнийг хамруулан 144.0 сая төгрөгийг олгосон байна.

Мөн 2024 онд Дорноговь аймгийн нийт нутгаар өвөлжилт хүндэрч мал их хэмжээгээр хорогдсонтой холбоотой малчдыг малжуулах үйл ажиллагааны хүрээнд 118 малчинд 968.0 сая төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хувиараа хөдөлмөр эрхлэгч 39 иргэнд 388.0 сая төгрөг, залуучуудын Старт-ап төсөлд 1 иргэнийг хамруулж 10.0 сая төгрөг, ахмад настанд олгох санхүүгийн дэмжлэгт 28 ахмадыг хамруулж 208.8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд 16 иргэнд 128.0 сая төгрөгийг олгосон байна.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/16 тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээ”-ний түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд анхаарах асуудлын хэсэгт мод тарих, нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэдийн ажлын хөлс, зардлыг аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн иргэний банкин дахь нэрийн дансанд шилжүүлэхээр заасан боловч 2023 онд нийтийг хамарсан ажилд хамрагдсан 457 иргэнд олгох 162.7 сая төгрөгийн санхүүжилтээс 68.3 сая төгрөгийг 9 сумын ЗДТГ-ын төсвийн нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд, 2024 онд 741 иргэнд олгох 274.6 сая төгрөгөөс 15.2 сая төгрөгийг Эрдэнэ, Иххэт сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд тус тус шилжүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн 2023 оны 02 дугаар тогтоолоор ХЭДС-ийн хэвийн үйл ажиллагааг явуулахад зориулж 3.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар шийдвэрлэснийг үндэслэн ХЭДС-ийн хөрөнгөөр 2023 онд 1.1 сая төгрөг, 2024 онд 1.3 сая төгрөгийн хувилэгч худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16.4.17-д заасан “Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн шууд захирагч байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээний 3.10-т “Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх үүрэгтэй” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Замын-Үүд сумын вакум цонхны үйлдвэрлэл эрхлэгч иргэн вакум цонхны материал худалдан авахаар төслийн зорилтод тусгасан боловч материалын нөөц бэлтгээгүй,
- Замын-Үүд сумын ахмад настан иргэн төсөлд тусгасан буузны үйлдвэрлэлд ашиглах зарим тоног төхөөрөмжийг бэлтгээгүй, сүүлийн 1 сарын хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй,
- Замын-Үүд сумын ХБИ төсөлд тусгасан 1 тоног төхөөрөмжийг аваагүй,
- Малжуулах төсөлд хамрагдсан Эрдэнэ сумын иргэн 5.0 сая төгрөгийн малыг худалдаж борлуулснаар А дансанд бүртгэсэн,

- Fohow сүлжээний бизнес эрхэлдэг Сайншанд сумын иргэний биоэнерги, бариа заслын үйл ажиллагаа явуулах 10.0 сая төгрөгийн төслийг дэмжиж дэмжлэг олгосон,
- Сайншанд сумын ХБИ-д хүргэлтийн хоолны үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж бэлтгэх зориулалтаар олгосон дэмжлэгийн хөрөнгөөр төсөлд тусгагдсан зарим тоног төхөөрөмжийг худалдаж аваагүй, автомашин авахад зарцуулсан,
- Сайншанд суманд мужаан, гагнуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ХБИ-д материал худалдан авах зориулалтаар дэмжлэг олгосон боловч үйл ажиллагаа явуулж байгаа эсэх нь тодорхойгүй, материал бэлтгээгүй байна.

- ✓ Санхүүгийн дэмжлэгт хамрагдаж 112.9 сая төгрөгийн дэмжлэг авсан 14 иргэн төсөлд тусгасан үйл ажиллагаа явуулаагүй, байнгын оршин суух хаягтаа байхгүй, өөр орон нутагт шилжиж суурьшсан, төсөлд заасан үйл ажиллагаа эрхэлж байгаа нь тодорхойгүй, ажлын байрыг хадгалаагүй байдалтай байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан иргэдийн төслийн хэрэгжилтэд хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байгаагаас санхүүгийн дэмжлэгийг зориулалт бусаар зарцуулах зөрчил гарсан байна.

2.1.3. Аудитад хамрагдсан хугацаанд ХЭДС-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 295 иргэний 30.5 хувь нь гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэ хуульд заасны дагуу олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнгийн болон санхүүгийн тайланг сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад заасан хугацаанд ирүүлэх үүрэгтэй” гэж заасан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгийг 5 хөтөлбөрийн хүрээнд 2023 онд 93 иргэний төсөлд 712.9 сая төгрөг, 2024 онд 202 иргэнд 1,702.8 сая төгрөгийг олгосон ба үүнээс 90 иргэн ХХҮГ-тай байгуулсан санхүүгийн дэмжлэгийн гэрээнд заасан үүргийг хэрэгжүүлээгүй, мөн 2014-2021 онуудад олгогдсон 94 иргэн 221.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг төлөх гэрээний үүргээ биелүүлээгүйгээс одоог хүртэл ХЭДС-д төвлөрүүлээгүй байна.

**ХЭДС-аас 2014-2024 онуудад олгосон санхүүгийн
дэмжлэгийн мэдээлэл**

Хүснэгт №10

/сая төгрөг/

№	Хөтөлбөрийн хэлбэр	2014-2021 он		2022-2024 он		Дүн	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	57	152.5	116	751.6	173	904.1
2	Ахмадын санхүүгийн дэмжлэг	1	1.2	45	167.7	46	168.9
3	Эмэгтэйчүүдэд олгох дэмжлэг			1	9.2	1	9.2
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох дэмжлэг	5	10.3	42	104.0	47	114.3
5	Малжуулах	31	57.1	144	888.4	175	945.5
	Нийт	94	221.1	348	1,920.9	442	2,142.0

ХЭДС-ийн 2024 оны нийт зарцуулалтын 58.6 хувийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зарцуулсан ба эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээний үүргийн биелэлтийг хангаагүйтэй холбоотой дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

1. Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээний 3.10 “Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан эргэн төлөлт хийх хуваарийн дагуу эргэн төлнө”, 4.5 “Олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хуваарийг зөрчсөн тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувиар хоног тутамд алданги тооцон нэхэмжилнэ” гэж заасан.

Гэтэл ХЭДС-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэд төлөлтийг гэрээнд тусгасан эргэн төлөх хуваарийн дагуу төлөөгүй, гэрээний хугацаа дууссан, 3 сараас дээш хугацаанд төлөөгүй, 2022 оноос хойш хугацаанд гэрээний үүргийг биелүүлээгүй нийт 39 иргэнтэй холбоотой 278.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн үлдэгдлийг төлөөгүй байна.

**Гэрээний хугацаанд төлөгдөөгүй үлдэгдэлд
ногдуулсан алдангийн тооцоолол**

Хүснэгт №11

/сая төгрөг/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан	Олгосон мөнгөн дүн	Төлөх дүн	Зээлийн үлдэгдэл	Тооцсон алданги	Нийт төлбөл зохих дүн
---	-----------------------	--------------------------------	--------------------	-----------	------------------	-----------------	-----------------------

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүн” - ГА

		иргэдийн тоо			/2025.05.31-ний байдлаар/		
1	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	33	319.9	319.9	252.6	111.6	364.2
2	Эмэгтэйчүүдэд олгох санхүүгийн дэмжлэг	1	10.0	10.0	9.2	4.6	13.8
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэмжлэг	4	29.6	17.1	12.3	6.0	18.2
4	Малжуулах	1	5.0	5.0	4.0	-	4.0
Нийт		39	364.5	352.0	278.1	122.2	400.2

Дээрх гэрээний үүргээ биелүүлээгүй 39 иргэнтэй холбоотой 278.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн үлдэгдэлд гэрээнд заасны дагуу 122.2 сая төгрөгийн алданги ногдуулж, ХЭДС-д буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

- Санхүүгийн дэмжлэгийг төлөх гэрээний хугацаа дуусах болоогүй боловч хуваарийн дагуу төлөөгүй хугацаа хоцроосон 81 иргэнтэй холбоотой 555.3 сая төгрөгийн дэмжлэгийн үлдэгдлийг төлөөгүй байна.

Гэрээний дуусах хугацаа болоогүй, хуваарьт хугацаанд төлөгдөөгүй дэмжлэгийн мэдээлэл

Хүснэгт №12		/сая төгрөг/		
№	Хөтөлбөр, арга хэмжээ	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн тоо	Олгосон мөнгөн дүн	Зээлийн үлдэгдэл /2025.05.31/
1	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	23	215.0	134.0
2	Ахмадын санхүүгийн дэмжлэг	5	40.0	29.9
3	Малжуулах	52	406.1	388.3
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	1	10.0	3.1
Нийт дүн		81	671.1	555.3

Дээрх эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй 555.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн үлдэгдлийг хуваарийн дагуу төлүүлж, хэвийн төлөвт оруулан гэрээний хэрэгжилтийг хангуулах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын хугацаанд гэрээний хугацаа дууссан, эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй нийт 149 иргэнтэй холбоотой 978.2 сая төгрөгийн дэмжлэгийн үлдэгдлээс 29 иргэнтэй холбоотой 81.0 сая төгрөгийг аудитын хугацаанд төлүүлсэн, үүнээс гэрээний хугацаа дууссан 12 иргэний 45.1 сая төгрөгийн дэмжлэгийн үлдэгдлийг барагдуулж дуусган, 17 иргэний хугацаа хэтэрсэн 35.9 сая төгрөгийг ХЭДС-д төлүүлж хэвийн төлөлтөд оруулсан.

ХЭДС-аас олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлттэй холбоотой зөрчлүүд дараах нөхцөлөөс шалтгаалж гарсан байна. Үүнд:

- ✓ ХХҮГ нь Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “ХЭДС-аас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.7-д заасан санхүүгийн дэмжлэгт хамрагдах этгээдтэй дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулах, тайлан мэдээ гаргах, эргэн төлөлт, хариуцлага, хяналтын асуудлыг тусгасан төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэх чиг үүргийг хэрэгжүүлээгүй.

- ✓ Мөн тус журмын 6.11-д заасан санхүүгийн дэмжлэгийг хууль бусаар ашигласан, эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийн бүртгэлийг хөтөлж олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлээгүй.
- ✓ Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийг аж ахуй эрхлэлтийн өмнөх болон дараах сургалтад хамруулан эрх, үүрэг, бусад холбоотой мэдээллийг өгсөн байгаа ч гэрээний үүрэг хангагдаагүй зөрчилд холбогдох хариуцлагын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлээгүйгээс зөрчлийн хэмжээ буураагүй байна.
- ✓ ХХҮЕГ-ын даргын баталсан гэрээний жишиг загварын 3.4 “Б талын эрх үүрэг”-т санхүүгийн дэмжлэгт тавигдсан нөхцөл, шаардлага, шалгуур, хүрэх үр дүнг бүрэн биелүүлж ажиллах гэсэн үүргийг ерөнхий утгаар оруулсан, мөн ХЭДС-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн төсөлд тусгагдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, өргөтгөх, ажлын байр шинээр бий болгох, хадгалах, хэрэгжих зэрэг төсөлд тавигдах тусгай нөхцөл, шаардлага, шалгуурыг гэрээний хавсралтад тусгаж батлаагүй байна.

Эдгээр нөхцөл байдлаас шалтгаалж ХЭДС-ийн эргэн төлөлтөөс бүрдэх эх үүсвэрийг бүрэн бүрдүүлэхгүй байх, сангийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулах, бусад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах боломжийг хязгаарлах, санхүүжүүлсэн төслийн зорилт хангагдахгүй, тогтмол ажлын байр хадгалагдахгүй байх зэрэг нөхцөлийг үүсгэсэн байна.

МУ-ын ЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан “ХЭДС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.1 “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг хөтлөх, сангаас олгох хөрөнгийн хэмжээг тодорхойлох, тогтоосон хугацаанд олгох, хяналт тавих, зохион байгуулах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гүйцэтгэнэ” гэж заасан.

Гэтэл ХХҮГ-ын хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтнууд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн төслийн үйл ажиллагааны явц, санхүүгийн дэмжлэгийн гэрээний хэрэгжилтийг үзэж, илрүүлсэн зөрчилд тухай бүр холбогдох арга хэмжээг аваагүй, зөрчилтэй этгээдийн бүртгэлийг хөтлөх, олон нийтэд мэдээлэх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс хамрагдагч иргэд гэрээний үүргийг биелүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

2.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтнууд чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нь хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд 2023, 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээ, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих талаар тусгаж, хэрэгжүүлээгүй, мөн Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь хууль, тогтоомж, дүрэм, журамд заасан хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

2.2.2. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлсэн хяналтаар өгсөн зөвлөмж, чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангах шаардлагатай байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30.1.5 “Төрийн захиргааны төв байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг бодлогын удирдамж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 30.1.6 “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эх үүсвэр, төсөв, тусгай зориулалтын сан, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтыг хийх, зарцуулалтад хяналт тавих, үнэлж дүгнэх”, 30.1.13 “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, хэрэгжилтийг тайлагнах” гэж заасан.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас 2023 онд аймгийн ХХҮГ-ын 2022 оны үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг зохион байгуулж хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 11 зөвлөмж хүргүүлж, анхан шатны баримтад үндэслэхгүй сургалтын зардал илүү шилжүүлсэн, нийтийг хамарсан ажлын хөлсийг тухайн иргэний нэрийн дансанд шилжүүлээгүй зэрэг зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, аймгийн ХХҮГ-аас хэрэгжилтийг 2023.08.31-ний өдрийн 347 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч, 2023, 2024 онуудад өмнөх зөрчил давтагдан гарсан нь зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

ХХҮГ-ын захиргаа, хяналтын хэлтсийн 2023 онд хэрэгжүүлэх дотоод хяналтын төлөвлөгөөнд 22 арга хэмжээг тусгаж батлуулсан, үүнээс ХЭДС-ийн үйл ажиллагаа, сангийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хяналт шалгалтын 2 арга хэмжээг тусгаж, хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2021, 2022 онуудад Сайншанд сумын харьяатай санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлыг 2023 онд хэрэгжүүлсэн боловч хяналт шалгалтын тайланд дэмжлэгт хамрагдсан иргэдийн нөхцөл байдлын талаар мэдээлэл тусгагдаагүй байна.

ХХҮГ-ын 2024 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөнд ХЭДС-ийн 2022, 2023 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт шалгалтын ажлыг тусгаж, удирдамжийн дагуу 2 удаагийн хяналт, шалгалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 13 сумын 45 иргэний ажлын байртай танилцан, санхүүгийн дэмжлэгийг төсөлд тусгасан зориулалтын дагуу зарцуулж байгаа, үйл ажиллагаа тогтвортой хэвийн явагдаж байгаа байдал, санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх хуваарийн дагуу төлж барагдуулж байгаа эсэх, гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулж ажилласан талаар тайлагнасан боловч аудитаар илрүүлсэн зөрчлийн дүн, байдал нь дотоод хяналт, шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн гэх байдал нотлогдохгүй байна.

ХХҮГ-аас дотоод хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөг жил бүр баталж, удирдамжийн дагуу хэрэгжүүлэн, тайлагнасан байх боловч цаашид гарах эрсдэлээс сэргийлэх дотоод хяналтын чиг үүргийг хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- ✓ Аймгийн Засаг даргын жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр тодорхой зорилтын хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж батлуулсан боловч орон нутаг дахь хөдөлмөр эрхлэлтийн бодит хэрэгцээ шаардлага, тоо мэдээлэлд үндэслэж төлөвлөөгүй байна.
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд орон нутагт ажилгүйдлийг бууруулах, шинэ ажлын байр бий болгох, ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа болон эх үүсвэрийг бодлогын төвшинд уялдуулан төлөвлөж, хамтарч хэрэгжүүлсэн байдал хангалтгүй байна.
- ✓ Хуульд заасан санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр зэрэг орлогыг бодитой тооцож төлөвлөөгүй байна.
- ✓ ХЭДС-аас иргэдийн бизнесийг дэмжих чиглэлээр олгож байгаа дэмжлэгийн санхүүжилтийн хэмжээ нь шинэ төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж бэлтгэх, ажлын байр барих, худалдан авах хэмжээний эх үүсвэрийг бүрдүүлж чадахгүй байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд нөлөөлж байна.
- ✓ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөг жил бүр батлан, удирдамжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнасан байх боловч ХЭДС-ийн зарцуулалт, олгосон санхүүгийн дэмжлэгийн зорилт хангагдсан эсэх, эргэн төлөлт, ажлын байр хадгалагдсан байдал зэрэг төслийн хэрэгжилтийг үзэж дүгнэн, цаашид гарах эрсдэлээс сэргийлэх дотоод хяналтын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлж, тухай бүр шийдвэрлээгүйгээс зарцуулалттай холбоотой зөрчил гарсан байна.
- ✓ Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд мод тарих нийтийг хамарсан арга хэмжээний зардал 83.5 сая төгрөгийг тухайн иргэний арилжааны банкин дахь нэрийн дансанд шилжүүлэхээр байтал 11 сумын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамжийг” зөрчсөн байна.
- ✓ ХЭДС-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 39 иргэнтэй холбоотой гэрээний хугацаанд төлөөгүй 278.1 сая төгрөгийн дэмжлэг, гэрээнд заасны дагуу тооцоогүй 122.1 сая төгрөгийн алданги, нийт 400.2 сая төгрөгийг төлүүлж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах арга хэмжээ аваагүй байна.
- ✓ Санхүүгийн дэмжлэг олгох гэрээний хавсралтад тусгасан эргэн төлөх хуваарийн дагуу дэмжлэгийг төлөөгүй 81 иргэнтэй холбоотой 555.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн үлдэгдлийг төлүүлэх, шийдвэрлэх арга хэмжээ аваагүй байна.
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- ✓ Аудитын хугацаанд гэрээний хугацаа дууссан болон эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй нийт 149 иргэнтэй холбоотой 978.2 сая төгрөгийн үлдэгдлээс 29 иргэнтэй холбоотой 81.0 сая төгрөгийг аудитын хугацаанд төлүүлж, үүнээс гэрээний хугацаа дууссан 12 иргэний 45.1 сая төгрөгийн дэмжлэгийн үлдэгдлийг бүрэн барагдуулж дуусган, 17 иргэний хугацаа хэтэрсэн 35.9 сая төгрөгийг ХЭДС-д төлүүлж хэвийн төлөлтөд оруулсан.

Аудитаар нийт 1,036.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын хугацаанд 30 иргэнтэй холбоотой 81.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг барагдуулан, төлбөр барагдуулах тухай 400.3 сая төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, зөрчил арилгах тухай 555.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, зөрчил давтан гаргахгүй байх тухай аймгийн ИТХ-д 2, аймгийн Засаг даргад 3, аймгийн ХЭЗ-д 1, ХХҮГ-т 2, нийт 8 зөвлөмжийг хүргүүлж, Үндэсний аудитын газарт 1 саналыг уламжилсан.